

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020 оны 7 дугаар сарын 03-ны өдөр

Тендерийн дугаар:МРЦМ/202004454

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь тус үйлдвэрийн газарт ISO 9001 Нэгдсэн менежментийн тогтолцооны хүрээнд ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001:2016 Байгаль орчны удирдлагын тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-т ISO 9001:2015 чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцоо, ISO 45001:2018 хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, сертификат авах цогц зөвлөхийн үйлчилгээ болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулбар бол нотариатаар баталгаажуулна/
- ШШГЕГ, харьяалагдах Шүүх, Нийгмийн даатгалын хэлтэс, харилцагч банкны тодорхойлолтыг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар гаргуулан авч ирүүлнэ.
- Сүүлийн 2 жилийн /2018, 2019 он/ борлуулалтын орлого нь 50 сая төгрөгөөс дээш байх.
- Зөвлөх нь ISO стандартуудын зөвлөх үйлчилгээ эрхлэх, баталгаажуулалт хийх тусгай зөвшөөрөлтэй байх,
- Хүний нөөцийн мэдээлэл ирүүлэх, /CV, тодорхойлолт/
- Чанарын менежментийн тогтолцооны ISO стандарт, бусад менежментийн арга хэрэгслүүдээр мэргэшсэн үйл ажиллагаа явуулж байсан мэдлэг туршлагатай зөвлөхүүдээр багаа бүрдүүлэх, төслийн ахлагч MBA болон түүнээс дээш зэрэгтэй байх,
- ISO стандартуудын зөвлөх үйлчилгээг үйлдвэрийн газарт 3 жил ба түүнээс дээш хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай байх, /сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн төсөл, гэрээт ажлын акт, нэвтрүүлсэн компанийн тодорхойлолт, тэдгээрийн мэдээлэл/
- Гадаадын нэг ба түүнээс дээш зөвлөхүүдтэй хамтарч ажилладаг байх, /үндсэн зөвлөхүүд болон хамтран ажиллах зөвлөхүүдийн намтар, ажлын туршлагын мэдээлэл/
- GAP шинжилгээ, чанарын болон тоон судалгааны боловсруулалт хийдэг программ хангамж, судалгаа явуулах арга аргачлал, мэдээллийн баазтай байх,
- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөртэй байх, сургалтад ашиглагддаг сүүлийн үеийн заах арга зүй, арга хэрэгслүүдтэй байх.
- Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 10 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 10 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х-002
Баянзүрх дүүрэг, 22-р хороо,
“Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 303 тоот,
И-мэйл: mailbox@monros.mn
Утас: 450060-112 Факс: 458380